

Л.ТРОЦКИЙ МОНГОЛТОЙ ХОЛБОГДОХ НЬ

Р.Болд

Монгол Улсын Тагнуулын ерөнхий газар

Өгүүллийн товч утга: Л.Троцкий Монголын талаар ямар үзэл бодолтой байсныг хөндөн харуулсан бөгөөд тэрээр Зөвлөлт Орос Улсаас Монголтой холбоотой шийдвэрүүд гаргахад оролцож, Монголыг тусгаар тогтносон Улс хэмээн үзэж байв.

Түлхүүр үг: Троцкий, Хятад дахь хувьсгалын асуудал, Монгол бол тусгаар тогтносон Улс.

Лев Давидович Троцкий-Бронштейн (1879-1940) нь марксист онолч, большевик хувьсгалыг зохион байгуулагчдын нэг байв. Л.Троцкий Зөвлөлт засаг тогтсоны дараа 1917-1918 онд Гадаад хэргийн Ардын анхны комиссараар ажиллажээ. Улаан гвардийн отрядууд 1918 оны 2 дугаар сард Германы армид ялагдсаны дараа байнгын арми байгуулах шаардлагатайг Зөвлөлт Засаг ойлгож, энэ үүргийг Л.Троцкийд хариуцуулсан байна. Л.Троцкий 1918 оны 3 дугаар сараас 1925 оны 1 дүгээр сар хүртэл Арми, Тэнгисийн цэргийн Ардын Комиссар, Цэргийн төв Зөвлөлийн даргаар ажиллажээ. Тэрээр цэргийн заавал хаах албан үүргийг хуульчлан тогтоож, хаант Засгийн армийн дадлага, туршлагатай офицерүүдийг Улаан Армид ашиглах үндсийг тавьж, Улаан гвардийн гэх тархай бутархай отрядуудыг нэгэн удирдлагатай, сахилга, зохион байгуулалттай байнгын Улаан Арми болгон эмхлэн байгуулах асар хүнд ажлыг нуруундаа үүрчээ. Ийм ч учраас судлаачид Л.Троцкийг Улаан Армийг үндэслэн байгуулагч гэж үздэг билээ. Лениний эрүүл мэнд эрс муудсанаар засгийн эрхийн төлөөх тэмцэл Лениний хамтран тэмцэгчдийн хооронд өрнөсөн байна. Ленин ч Сталины эсрэг тэмцэлд Троцкийг түшиглэх зорилгоор түүнд хандан 1922 оны намар Совнаркомын буюу өөрийнх нь орлогч болох хүсэлт тавьсан боловч тэрээр хүлээн авсангүй. Ингэснээр Троцкий Ленинд туслахаас татгалзсан байна. Энэхүү тэмцэлд Сталин ялсанаар Троцкий 1928 оны 1 дүгээр сард Алма Атад цөлөгдөж, жилийн дараа ЗХУ-аас хөөгдөж Туркэд очжээ. Троцкий Турк, Франц, Норвегид цагаачлан амьдарч байгаад 1936 онд Мексикт дүрвэн очжээ. Тэрээр 1940 онд Мехикод Зөвлөлтийн нууц туршуулын гарт амь үрэгджээ. Л.Троцкий Зөвлөлт засгийн зүтгэлтэний хувьд хэдийгээр одоохондоо эх сурвалж ховор боловч Монголын талаар ямар үзэл бодолтой байсныг цухасхан боловч харуулахыг оролдов.

Троцкий цөллөг, цагаачлалын үеэр

Хувьсгалын хэрэгт оролцсоны учир Л.Троцкий 1899 онд 4 жилээр цөллөгджээ. Тэрээр Лена мөрөнгийн эрэгт Байгаль нуураас баруун умард зүгт орших Усть-Кут нэртэй жижиг тосгонд хоёр жилийг (1900-1902) өнгөрөөжээ. Чингэхдээ тэрээр Монголын зах хязгаарт тун ойрхон байгаагаа нөхөддөө илгээсэн захидалдаа дурдан бичиж байжээ¹. Тэрээр цөллөгнөөс Эрхүүгээр дамжин оргосон боловч 1905 оны хувьсгалд оролцсоны учир дахин баривчлагдаж 1907 онд Якут хавьд Обдорск тосгонд дахин цөллөгджээ. Троцкий Якут, Монголын ялгааг нутгийн иргэдээс олонтай асуун эрэгцүүлж байсныг түүний гэргий сүүлд дурсан бичсэн байна. Троцкий цөллөгнөөс дахин оргож улмаар Европт дүрвэн гарчээ. Тэрээр Австри, Герман, АНУ-аар хэсүүлэн явахдаа хаант Оросын бодлогыг эсэргүүцсэн өгүүллэгүүд олныг нийтлүүлсэн байна. Тухайлбал Орос, Хятадын харилцааг ажиглан бичихдээ “Монголд автономи олгох нэрийдлээр Оросын эрх баригчид шинэ Хятадыг

¹ Joel Carmichael “Trotsky: A n Appreciation of his Life” London 1975 p.64

хэсэгчлэн хуваахыг оролдож улмаар Алс дорнодод сүйрлийг зөгнөж байна...Оросын тариачин олонд падгүй Монголын асуудлаар хаант Орос оролдох нь юун..." хэмээжээ².

Монголд Улаан Армийг оруулах асуудал

Сибирийн хувьсгалт хорооны дарга Смирнов 1921 оны 3 дугаар сарын 25-нд Ленинд илгээсэн цахилгаандаа "Хятадад, баруун монголд байгаа зугтсан Дутовын цагаан гвардийн дээрэмчид бутарч байна. Тэдний зүгээс Зөвлөлт Орост буцаж ирэхийг зөвшөөрөх хүсэлт ирэв. Таван мянга орчим хүнтэй юм. Семипалатинскийн Гүйцэтгэх хороонд чиглэл өгсөн..." гэжээ. Ленин уг цахилгаанд Троцкийд хандан Монголд үүрлэсэн цагаантнуудын талаар анхаарах цохолт хийжээ³.

Монгол Ардын Түр Засгийн газар Зөвлөлт Засагт хандаж Зөвлөлт Оросын цэрэг ирүүлэх хүсэлтийг 1921 оны 4 дүгээр сарын 10-нд тавьсан боловч Москва шийдвэр гаргалгүй байсаар 1921 оны 6 дугаар сар гарчээ. Энэ хооронд Барон Унгерний цэрэг Зөвлөлт Оросын хилд цөмрөн орж байлдан улмаар ухарсан зэрэг үйл явдал өрнөж нөхцөл байдал түгшүүртэй болжээ. Иймд Гадаад хэргийн ардын комиссар Г.В.Чичеринээс 1921 оны 6 дугаар сарын 13-нд БХК(б)Н-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга Молотовт хандан Монголын нутагт цөмөрсөн Барон Унгерний цэргийг устгахын тулд Монголд Улаан Арми болон АДБНУ-ын цэргийн аялан байлдан корпусыг илгээх, энэхүү асуудлыг Хятадын засгийн газарт ойлгуулах, яриа хэлцээ хийлгэхээр Юрийийг илгээх саналыг УТТ-ны хуралдаанаар хэлэлцүүлж, уг асуудлыг нэн даруй шийдвэрлүүлэх саналыг тавьжээ. Чичерин АДБНУ, Сибирийн аюулгүй байдлыг хангахын тулд Монголд цэргээ илгээх чингэхдээ нутаг дэвсгэрийн талаар хятадын бүрэн эрхийн зарчмыг уг дуугүй баримтлах, Монголын өөртөө засан тохинох, үндэсний эрх чөлөөгөө олох програмыг баримталвал зохих бөгөөд үүний тулд МАХН-тай бүрэн дүүрэн зөвшин тохирч, хэлхээ холбоотой байхын хамт монголын улаан цэргийн ангиудтай хамтран ажиллах... Хятадын цэрэгтэй тулгарвал холбоотны ёсоор харилцаж, Хятадын эрх ашгийг хамгаалж байгааг ойлгуулах учиртайг дурдсан байна⁴.

Л.Троцкий Монголд цэрэг оруулах асуудлыг нэн даруй шийдвэрлэхийг өөрийн орлогч Э.Склянскийд⁵ чиглэл болгожээ. Үүний дагуу Склянский дараах байдлаар Ленинтэй 1921 оны 6 дугаар сарын 14-15-ны орчимд харилцсан байна. Склянский "Владимир Ильич, Монгол уруу хөдлөх асуудлыг бид шийдсэн үү? Нэн даруй чиглэл өгөх хэрэгтэй байна", Ленин "Молотовтой өнөөдөр тохирлоо, тэр Улс төрийн Товчоонд утсаар асуудлыг оруулахаар амалсан, Склянский "Та дэмжиж байгаа юу?" гэжээ⁶.

Монголд цөмөрсөн Барон Унгерний цэргийг устгахаар Монголд Зөвлөлт Оросын цэргийг оруулах асуудлыг БХК(б)Н-ын Төв Хорооны УТТ-ны хуралдаанаар 1921 оны 6 дугаар сарын 16-нд хэлэлцэн шийдвэрлэхэд Ленин, Троцкий, Зиновьев, Бухарин, Радек, Каменев, Молотов нар оролцжээ. Хуралдаанаар Монголд илгээх тусгай зориулалтын отрядыг зохион байгуулах талаар онцгой анхаарч, энэ талаар практик саналаа болж өгвөл бичгээр...УТТ-нд оруулахыг Троцкийд даалгажээ⁷. Энэхүү шийдвэрийн үндсэн дээр

² The War correspondence of Leon Trotsky: The Balkan Wars 1912-1913 p.318-319

³ Jan M.Meijer The Trotsky Papers 1917-1922 II 1920-1922 1971 Mouton The Hague-Paris p.432-434

⁴ Монголын тухай БХК (б)Н-ын баримт бичигт 1920-1932 I дүгээр боть УБ.2002 т.84-86

⁵ Е.Склянский-Цэргийн Төв зөвлөлийн орлогч дарга (1918-1924). Троцкийн хамтран зүтгэгч, найдвартай туслагч байв. М.Фрунзе 1924 онд Цэргийн Төв зөвлөлийн орлогчоор томилогдож, Склянский өөрчлөгдсөнөөр Троцкийн нөлөө, байр суурь цэргийн салбарт суларчээ.

⁶ Jan M.Meijer The Trotsky Papers 1917-1922. II 1920-1922. 1971 Mouton The Hague-Paris p.432-434

⁷ Монголын тухай БХК (б)Н-ын баримт бичигт 1920-1932 I дүгээр боть УБ.2002 т.86

Монголд цэрэг оруулах асуудлыг Хятадын засгийн газарт албан ёсоор ноотоор мэдэгдсэн байна. Улмаар Троцкийн өгсөн чиглэлийн үндсэн дээр 1921 оны 6 дугаар сарын 18-нд Сибирийн цэргийн командлагч Шорины захирамж гарч, Улаан Армийн аялан байлдах корпусын ангиуд 6 дугаар сарын 27-нд Монголын зүгт хөдөлжээ. Дээрхээс үндэслэн Монголд үүрлэсэн Барон Унгерний хүчийг устгах цэргийн ажиллагааг эхлүүлэх, хэрэгжүүлэх явдал Арми, Тэнгисийн цэргийн ардын комиссар, Цэргийн төв зөвлөлийн дарга Л.Троцкийн шууд оролцоотой явагдсан гэж үзэж болох юм.

БХК(б)Н-ын Төв Хорооны УТТ-ны 1921 оны 6 дугаар сарын 20-ны хуралдаанаар МАХН-д хоёр зуун мянган мөнгөн рублийн мөнгөн тусламж үзүүлэх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхэд Троцкий оролцож дэмжсэн байна⁸. Мөн Монголд Барон Унгерний эсрэг байлдааны ажиллагаа явуулах үед Монголын хүн амд учруулсан хохирлыг нөхөн төлөх асуудлаар дүгнэлт гаргахад бэлтгэх комисс байгуулах тухай асуудлыг БХК(б)Н-ын Төв Хорооны УТТ-ы хурлаар хэлэлцсэн 1921 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанд Ленин, Сталинаас гадна Троцкий оролцож, монголын ард иргэдэд 500 мянган рублийн нөхөн төлбөр олгохыг шийдвэрлэж байжээ⁹.

Монголын тусгаар тогтнол ба Троцкий

Хятад дахь хувьсгалын шинж чанар, хөдөлгөгч хүчний талаар Троцкий Сталинтай зарчмын ялгаатай байр суурь баримталж зөрөлдөж байв. Тухайлбал Троцкий ХКН-ыг дэмжиж байсан бол Сталин Гоминданыг дэмжиж Чан Кайшитай харилцаагаа таслахыг яарахгүй байв. Троцкий ХКН-ыг үндэслэн байгуулагчидтай илүү ойр дотно харилцаатай тэднийг дэмжиж байв.

Монголын талаарх Троцкийн байр суурийг Чан Кайши тэмдэглэн үлдээжээ. Чан Кайши “1923 оны эхээр Йоффе доктор Сун Ятсен-тай уулзахдаа Зөвлөлт Орос нь улс төрийн практикт Ар Монголын талаарх империалист бодлогыг үргэлжлүүлэхгүй бөгөөд түүнийг Хятадаас салгахад тус дөхөм үзүүлэхгүй хэмээн хоёрдмол утгагүйгээр мэдэгдсэн юм. Гэвч Зөвлөлтийн удирдагчидтэй ярилцаж байхдаа Ар Монголын талаарх түрэмгий бодлогоос тэд татгалзаагүйг нь анзаарсан юм. Энэ нь үндэсний тусгаар тогтнол, эрх чөлөөгөө Хятадыг олоход туслах Зөвлөлт Оросын санал нь хэр чин үнэнтэйг тодорхойлох миний шалгуур болсон юм” хэмээн бичжээ. БХК(б)Н-ын удирдлага Хятадын хувьсгалын талаар санал хуваагдсан 1926-1927 оны үед Троцкий Сталины эсрэг байр суурийг баримталж байв. В.Ленин өвчтэй байсан тул Троцкий Хятадын коммунист нам, Гоминданы төлөөлөгчдийг хүлээн авч уулзан дэлхийн болон Хятад дахь хувьсгалын зорилт, шинж чанарын талаар олонтай ярилцаж байжээ. Иймд Чан Кайшигийн дүгнэлт гол төлөв Троцкийтэй хийсэн уулзалтын дүнд хийгджээ гэх үндэслэл байгаа юм. Ленин өвчтэй байсан тул Зөвлөлтийн удирдагчдаас Чан Кайши Троцкийтэй илүү олонтай уулзаж ярилцдаг, Троцкий ч илүүтэй илэн далангүй байсныг тэрээр тэмдэглэжээ.

Москвагаас буцахаас өмнөхөн Троцкийтэй хийсэн сүүлчийн нэгэн уулзалтын үеэр бид Ази дахь хувьсгалт хөдөлгөөний талаар ярилцсан. Троцкий Зөвлөлт Оросын талаас Герман, Польшийн хувьсгалт хөдөлгөөнд тусламж үзүүлэх оролдлого бүтэлгүйдсэний шалтгааны талаарх өөрийн үзэл бодлыг дэлгэн тайлбарласан. Польштой хийсэн дайны дараа Ленин дэлхийн хувьсгалд бэлтгэх шинэ чиглэл өгсөн. Чиглэлийн агуулга нь колонийн орнуудаас капиталистуудын эсрэг явуулах хувьсгалт дайнд ёс суртахууны болон материаллаг туслалцаа үзүүлэхийн хамт Зөвлөлт Орос өмнөх шигээ интервенц хийх, өөрийн цэргийг хэрэглэх явдлаас бүрмөсөн татгалзахаар шийдсэн. Учир нь цэргийн хүч хэрэглэснээр тухайн улс орнуудын үндэсний ухамсартай мөргөлдөх явдал гарч болзошгүй тул үүнээс зайлсхийх шаардлагатайг тооцсон гэж Троцкий ярьжээ¹⁰.

⁸ Монголын тухай БХК (б)Н-ын баримт бичигт 1920-1932 I дүгээр боть УБ.2002 т.90

⁹ Монголын тухай БХК (б)Н-ын баримт бичигт 1920-1932 I дүгээр боть УБ.2002 т.106

¹⁰ Чан Кайши “Советский Союз в Китае” 1961.Издательство “Посев” Франкфурт на Майне с.24-25

Чан Кайши 1923 оны 9 дүгээр сард эхнэртээ илгээсэн захидалдаа "...хувьсгалч хүнд байх ёстой идэвхтэй, тэсвэртэй чанаруудаараа Троцкий надад маш их таалагдлаа, учир нь эдгээрийн аль нэггүйгээр юу ч хийж чадахгүй. Троцкий бол Орост хамгийн нөлөөтэй хүн. Ар Монголыг Хятадад буцаан өгөх асуудлын чухлыг түүнд дурдан ярьсан боловч энэхүү сэдвээр тэр ам ч ангайсангүй" гэж бичиж байжээ¹¹. Чан Кайши гоминданы гишүүдийг Улаан Армийн цэргийн албан хаагчдын адилаар Ар Монголд сургаж бэлтгэх, дараа нь Бээжинг эзлэх саналыг Троцкийд тавьсан боловч тэрээр татгалзжээ. Троцкий цэргийн маршийг Монголоос биш харин Хятадын өөрийн нутгаас хийхийг зөвлөсөн байна. Чан Кайши Ар Монголын асуудлаар Троцкийтэй ярилцсаны дараа Зөвлөлтийн удирдагчид Монголыг тусгаар улс хэмээн үзэх бодолтойг ойлгожээ.

Сталин АНУ-ын хэвлэлийн бюзнессийн төлөөлөгч Ховардад 1936 оны 3 дугаар сарын эхээр Алс дорнодын байдлын талаар ярилцлага өгөхдөө хэрэв Япон БНМАУ-д довтолвол түүнийг 1921 онд хамгаалсантай адилаар хамгаалах болно гэж мэдэгдсэн билээ. Сталины ярилцлагыг Л.Троцкий задлан шинжилсэн өгүүллэгээ АНУ-ын "The New Militant" сэтгүүлийн 1936 оны 4 дүгээр сарын 4-ны дугаарт нийтэлжээ.

Зөвлөлтийн тал Дорнод Хятадын төмөр замыг Япон-Манжго-д худалдсаныг шүүмжлэн бичихдээ "стратегийн ач холбогдолтой чухал шугамыг найр тавин өгсөнөөр Зөвлөлт Засгийн газар Японоос Умард Хятадыг эзлэх, улмаар Монголыг одоо довтолж байгаа явдлыг өөгшүүлж байна. ..гэхдээ одоо байдал дээрдсэнээр Зөвлөлтийн тал Монголын асуудлаар бүрэн "хориг тавих" боломжтой болов. Монголын асуудал нь зөвхөн өөрийн газар нутгийг хамгаалах төдий асуудал биш, Монгол бол тусгаар тогтносон Улс..." гэжээ. Үүгээр Троцкий Зөвлөлтийн тал Монголыг хамгаалахын тулд олон улсын тавцанд дипломат алхам хийх ёстойг өгүүлжээ.

Троцкий "Хувьсгалаас урвасан нь" хэмээх бүтээлдээ (1937) "Монгол нь ямагт ЗХУ-тай хийх ирээдүйн дайнд Японд эзлэгдэх эсэхтэй холбоотой стратегийн асуудал байх болно. Японы цэрэг Монголд дайн хийж нэвтрэхэд ямар хариулт өгөх эсэхийг илэн далангүй мэдэгдэх тийм л мөчид Зөвлөлт засгийн газар тулж ирээд байна. Гэхдээ энэ нь "өөрийн газар нутгийг хамгаалах" асуудал биш учир нь Монгол бол тусгаар тогтносон Улс" хэмээн дахин давтан өгүүлжээ¹².

Зөвлөлт Засгийн анхны удирдагчид Монгол бол тусгаар тогтносон Улс хэмээн үзэж байв. Тэдний хоорон дахь засгийн эрхийн төлөөх тэмцлийн нэг асуудал нь Хятадын хувьсгалын талаарх зөрөлдөөнтэй байр суурь байв. Хэрэв Сталинаас өөр хэн нэг нь Ленинийг залгамжилсан бол Монголын тусгаар тогтнолын асуудал олон улсын эрх зүйн дагуу шийдэгдэж нөхцөл байдал арай өөрөөр эргэх боломж байсан болов уу...

Abstract

Despite the fact that the subject is less studied earlier and has limited sources available, the article's intended purpose is to shed a light on the view of Leon Trotsky, as a Soviet statesman, regarding Mongolia and the matters of its status quo. A firm critic of Imperial Russian involvement in Mongolia before the October Revolution, Trotsky was directly responsible behind the Red Army intervention in the country, presenting financial assistance, and granting war repatriation for the Mongolians in 1921. A fierce rival of Stalin in the struggle for power in post-Lenin Soviet supremacy vacuum and a sharer of a different standpoint in the Chinese Revolution process, Trotsky viewed Mongolia as an independent state, willing to make commitments to it.

¹¹ "Chiang Kai-Shek's Secret Past" Westview press. 1993 p.131

¹² Leon Trotsky "The Revolution Betrayed" 1937 p.146